

# Солонгост оршин суугаа гадаадын иргэн COVID-19 халдварын эсрэг вакцинд хэрхэн хамрагдах тухай заавар

Солонгост оршин сууж буй гадаад иргэн нь Солонгос иргэний нэгэн адил жишиг зааварын дагуу урьдчилсан захиалгад хамрагдах болно. Доорх вакцинд хамрагдах хүн болон урьдчилсан захиалга хийх аргын талаарх заавартай танилцан COVID-19 вирусийн эсрэг вакцинжуулалтын захиалга гаенөүү.

## □ Вакцинд хамрагдах хүн болон урьдчилсан захиалга хийх арга

### ◦ Гадаадын иргэний бүртгэлтэй гадаад иргэн

- '8~9сарын вакцинжуулалтын төлөвлөгөөний дагуу' дэс дараалалтайгаар вакцинжуулалтын захиалга хийх ба захиалгыг онлайнаар болон утсаар ярьж хийх боломжтой.
- \* Онлайнаар захиалга хийх үед 'захиалганд хамрагдах хүн биш байна' гэж гарч ирвэл харьяа эрүүл мэндийн төвд очиж бүртгүүлсний дараа захиалга хийх боломжтой.

- Урьдчилсан захиалга хийх арга-

- **(Онлайн захиалга хийх - хувь хүн өөрөө болон өөр хүн төлөөлөн хийх боломжтой)** COVID-19 вирусийн эсрэг урьдчилан захиалгын систем(<http://ncvr2.kdca.go.kr>)т нэвтрэн орж захиалга өгөх (**8сарын 25ны 0цагаас эхлэн өөр хүн төлөөлөн захиалга хийх боломжтой**)
- **(Утсаар ярьж захиалга хийх - өөрөө эсвэл өөр хүн төлөөлөн хийх боломжтой)** Халдварт өвчин судлалын газрын дуудлагын төв(1339) эсвэл COVID-19 вирусийн эсрэг урьдчилан захиалгын систем(Вакцинжуулалтанд хамрагдсан байдал(хулганаа тавих ) → COVID-19 эсрэг вакцинжуулалтын утсаар захиалга хийх байгууллагын байдал гэсэн хэсэгт дарах)ээс орон нутгийн засаг захиргааны захиалгын талаар зөвлөгөө авах утасыг шалгах

### ◦ Гадаадын иргэний бүртгэлийн дугаар(үнэмлэх)гүй гадаадын иргэн(хууль бусаар оршин сууж буй гадаад иргэн )

- Онлайн болон утсаар ярьж захиалга хийх боломжгүй
- Бус нутгийн эрүүл мэндийн төвд очиж гадаад паспортаар түр хяналтын дугаар авснаар вакцинжуулалтын захиалга хийх боломжтой.

※ **Аялал жуулчлалын зорилгоор Солонгост ирээд байгаа 90 ба түүнээс доош хоногийн богино хугацааны оршин суугчид**

- Вакцинжуулалтад хамрагдах боломжгүй.

## □ Анхаарах зүйл

- **Урьдчилсан захиалгын бүртгэлийн дараа вакцинжуулалтын талаар мэдээлэл авах гэж буй гадаадын иргэний бүртгэлтэй иргэн нь гар утасны дугаар солигдсон тохиолдолд шинэчлэх ёстой**
- Гар утасны дугаар өөрчлөгдсөн тухай мэдээлэлийг харьяа цагаачлалын албанад мэдэгдэнэ үү
- **Хувийн мэдээллийг зөвхөн вакцинжуулалтад хамруулах зорилгоор ашиглах, бөгөөд мэдэгдэх үүргээс чөлөөлөх журмын дагуу цагаачлалын албанад хууль бус оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.**
- **Тарилгад хамрагдах газар нь тухайн хүн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхээс хамаарч хязгаарлалт байж болно.**

<Энэ орчуулгыг Данури төв 1577-1366 хийсэн болно>